



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/264

Чингис хот

Аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2,3 Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам, 2020 оны Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 104 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хуваарьт өөрчлөлт орсон болон Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуульд олон улсын стандарт нэвтрүүлэх бэлтгэл хангах арга хэмжээ зохион байгуулахтай холбогдуулан нэгдсэн төсвийн орлого, зарлагын сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулсугай.

2. Нэгдсэн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, нэгдсэн төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Батлагдсан төсвийг хуваарийн дагуу захиран зарцуулахыг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

4. Төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын 24-ний өдрийн А/641 захирамжийн нэг, хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010743